

Журам шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Сангийн сайдын 2016 оны 41 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ ЖУРАМ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг тогтооход энэхүү журмын зорилго оршино.

1.2.Аж ахуйн нэгж, байгууллага, төлөөний газар, улс төрийн нам, сууц өмчлөгчдийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн хороо, өрхийн эрүүл мэндийн төв, мэргэжлийн холбоо, мэргэжлийн нэгдсэн холбоо /цаашид “тайлагнагч байгууллага” гэх/-ны санхүүгийн тайланд үндэслэн И-Баланс цахим систем /цаашид “цахим систем” гэх/-ээр ангиллыг тогтооно.

ХОЁР.НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ

2.1.Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулдаг, эсхүл бүтээгдэхүүн ажил үйлчилгээний үнэ өртөг, эсхүл үйл ажиллагаа нь нийтийн эрх ашигт нөлөөлдөг бол нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллага гэж үзнэ.

2.2.Нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллагад дараах аж ахуйн нэгж, байгууллагууд хамаарна: Үүнд:

2.2.1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.2.1-4.2.7-д заасан байгууллагууд;

2.2.2.Аудитын тухай хуулийн 10.1.1-10.1.6-д заасан байгууллагууд;

2.2.3.энэ журмын 3.1-т заасны дагуу “том аж ахуйн нэгж” гэсэн ангилалд хамаарах байгууллагууд.

ГУРАВ.АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ

3.1.Тайлагнагч байгууллагын нийт хөрөнгийн хэмжээ 1.0 тэрбум төгрөгөөс дээш, эсхүл борлуулалтын орлогын хэмжээ 2.5 тэрбум төгрөгөөс дээш бол “том аж ахуйн нэгж, байгууллага” гэсэн ангилалд хамаарна.

3.2.Тайлагнагч байгууллагын нийт хөрөнгийн хэмжээг тухайн жилийн санхүүгийн тайланд үндэслэн нийт хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдлийн арифметик дунджаар тооцно.

3.3.Тайлагнагч байгууллагын борлуулалтын орлогын хэмжээг тухайн жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлого /цэвэр/ гэсэн мөрөнд тусгагдсан дүнгээр тооцно.

3.4.Тайлагнагч байгууллагын ангиллыг анх удаа тогтоохдоо тайлант үеийн эцсийн үлдэгдлийн нийт хөрөнгийн хэмжээ эсхүл борлуулалтын орлогын /цэвэр/ хэмжээнд үндэслэн цахим системээр тогтооно.

3.5.Тайлагнагч байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө эсхүл борлуулалтын орлогын хэмжээнд үндэслэн 2 жил тутамд цахим системээр шинэчлэн тогтооно.

ДӨРӨВ.САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙЛГЭХ

4.1.Нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, тус журмыг дагаж мөрдөх бөгөөд Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу санхүүгийн тайланд заавал аудит хийлгэнэ.

4.2.Жижиг дунд аж ахуйн нэгж, байгууллага нь тендерт оролцох, өөрчлөн байгуулагдаж байгаа болон татан буугдах зэрэг бусад тохиолдолд санхүүгийн тайландаа, иргэн санхүүгийн баримтдаа аудит хийлгэж болно.

ТАВ.ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

5.1.Энэ журмыг зөрчсөн тайлагнагч байгууллагад Зөрчлийн тухай хуульд заасны дагуу харилцагч санхүүгийн байгууллага хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----